



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/162/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: М.Айнур Утас: 94159291 Цахим хаяг: ainurmarkh@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ,
БҮРДҮҮЛЭЛТИЙН АЛБАНЫ ДАРГА
Ж.УЛАМБАЯР ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠒.14 № 44
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Гаалийн газар-Дүгнэлт

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,  М.ХУАНГАН



Гаалийн газар-Дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>37,861,097.81</u>	<u>53,390,681.81</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг		
31120	Гадаад валют		
31130	Нэмэлт санхүүжилт		
31140	Касс арилжааны банк		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31212	Монгол банкин дахь харилцах		
31213	Арилжааны банк дахь харилцах		
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах		
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк		
33	АВЛАГА	-	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага		
33400	Зээлийн хүүгийн авлага		
335	Бусад авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага	-	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	37,861,097.81	53,390,681.81
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал		
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,460,430.00	1,465,064.00
354	Хангамжийн материал	36,400,667.81	51,925,617.81
35410	Бичиг хэргийн материал	300,000.00	291,000.00
35420	Аж ахуйн материал	-	9,770,410.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	9,604,370.00	14,018,910.00
35450	Барилгын засварын материал	-	-
35460	Хүнсний материал	-	-
35470	Бусад хангамжийн материал	26,496,297.81	27,845,297.81
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,899,840,925.38</u>	<u>3,931,219,724.43</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,899,840,925.38	3,931,219,724.43
391	Газар	177,324,000.00	177,324,000.00
392	Биет хөрөнгө	2,679,589,663.38	3,712,632,212.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,181,892,208.17	2,228,996,033.17

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39202	Хуримтлагдсан элэгдэл	(205,639,861.62)	(306,334,225.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	261,812,170.00	296,312,170.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(261,812,170.00)	(296,312,170.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,622,503,723.53	2,911,190,073.53
39206	Хуримтлагдсан элэгдэл	(956,330,539.61)	(1,157,146,504.95)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,566,541.71	91,581,341.71
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,655,347.42)	(57,697,197.44)
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,685,872.11	3,665,872.11
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,432,933.49)	(1,623,180.46)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном		
393	Биет бус хөрөнгө	42,927,262.00	41,263,512.04
39301	Програм хангамж	42,927,262.00	42,927,262.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,663,749.96)
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,937,702,023.19</u>	<u>3,984,610,406.24</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг		
41350	Зээлийн хүүгийн өглөг		
4136	Бусад өглөг	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг	-	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,937,702,023.19</u>	<u>3,984,610,406.24</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,937,702,023.19	3,984,610,406.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,204,498,119.19	5,204,498,119.19
51101	Өмч: - төрийн		
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
51104	Халаасны хувьцаа		
51105	Нэмж төлөгдсөн капитал		
51106	Эздийн өмчийн бусад хэсэг		
512	Хуримтлагдсан үр дүн	(2,266,796,096.00)	(1,219,887,712.95)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,266,796,096.00)	(2,266,796,096.00)
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,046,908,383.05
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,937,702,023.19</u>	<u>3,984,610,406.24</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,608,289,705.00	2,376,659,613.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,040,920.00	1,305,878,913.37
120	Нийтлэг татварын бус орлого	3,040,920.00	1,305,878,913.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,303,867,533.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,303,867,533.37
120005	Түрээсийн орлого	926,100.00	
120006	Газрын тосны орлого		
120009	Бусад орлого	2,114,820.00	2,011,380.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,605,248,785.00	1,070,780,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,605,248,785.00	1,070,780,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,044,695,100.00	1,070,780,700.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх		
131005	Хөрөнгийн санхүүжилт	560,553,685.00	
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,129,214,358.37	1,329,719,550.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,129,214,358.37	1,329,719,550.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,105,776,101.42	1,296,938,253.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	674,173,336.11	711,021,847.94
210101	Үндсэн цалин	636,313,212.87	654,014,822.69
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,356,000.00	37,579,000.00
210104	Урамшуулал		
210105	Гэрээт ажлын хөлс	19,504,123.24	19,428,025.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,437,830.52	93,214,631.85

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	84,437,830.52	93,214,631.85
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,554,529.60	75,375,291.83
210301	Гэрэл, цахилгаан	39,646,487.12	31,413,483.61
210302	Түлш, халаалт	42,906,042.48	43,016,972.22
210303	Цэвэр, бохир ус	1,002,000.00	944,836.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	24,363,791.20	27,869,065.70
210401	Бичиг хэрэг	3,332,200.00	3,576,200.00
210402	Тээвэр, шатахуун	14,535,400.00	16,715,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,331,649.20	1,500,195.70
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,312,750.00	2,669,380.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,851,792.00	3,407,490.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,562,968.00	56,389,195.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,280,500.00	419,600.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,423,880.00	40,177,360.00
210604	Урсгал засвар	14,858,588.00	15,792,235.00
2107	Томилолт, зочны зардал	4,407,700.00	4,000,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4,407,700.00	4,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,369,331.00	30,241,212.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,448,800.00	24,037,274.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000.00	490,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,438,300.00	2,438,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	178,900.00	134,300.00
210807	Газрын төлбөр	565,476.00	565,476.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,245,855.00	2,476,862.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,906,614.99	298,827,009.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	174,906,614.99	298,827,009.32
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,438,256.95	32,781,296.68
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,438,256.95	32,781,296.68
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,438,256.95	32,781,296.68
213304	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	479,075,346.63	1,046,940,063.05

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	31,680.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
225002	Найдваргүй авлагын алдагдал		
225003	Хөрөнгө оруулалтын гарз		
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	31,680.00
225006	Гадаадын төслийн зээлээс санхүүжих дамжуулан зээлдүүлэх		
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		
225008	Дотоод эх үүсвэрээс олгосон зээл		
225009	Дамжуулан зээлдүүлэх зээл		
230001	Эргэж төлөгдөх зээл		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(31,680.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>479,075,346.63</u>	<u>1,046,908,383.05</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,204,498,119.19	-	-	2,458,626,676.56
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-778,186,489.96	-778,186,489.96
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,204,498,119.19	778,186,489.96	2,745,871,442.63	1,680,440,186.60
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	778,186,489.96	0.00	778,186,489.96
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн			479,075,346.63	479,075,346.63
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,204,498,119.19	0.00	-	2,937,702,023.19
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,204,498,119.19	778,186,489.96	-	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,204,498,119.19	0.00	-	2,937,702,023.19
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			1,046,908,383.05	1,046,908,383.05
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,204,498,119.19	0.00	-	3,984,610,406.24
			1,219,887,712.95	

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,046,388,600.00	1,070,780,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,693,500.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,693,500.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
120005	Түрээсийн орлого	1,543,500.00	-
120009	Бусад орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,044,695,100.00	1,070,780,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,044,695,100.00	1,070,780,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,044,695,100.00	1,070,780,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	961,437,788.00	1,017,246,075.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	961,437,788.00	1,017,246,075.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	937,382,131.05	984,464,778.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	663,815,620.47	709,382,725.44
210101	Үндсэн цалин	371,054,193.76	394,497,825.44
210102	Нэмэгдэл	213,964,910.34	215,964,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,196,516.37	39,920,000.00
210104	Урамшуулал	61,600,000.00	59,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,680,726.16	92,842,374.35
210201	Тэтгэврийн даатгал	92,680,726.16	92,842,374.35
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,500,541.22	80,108,031.83
210301	Гэрэл, цахилгаан	39,646,487.12	31,413,483.61
210302	Түлш, халаалт	47,852,054.10	47,749,712.22
210303	Цэвэр, бохир ус	1,002,000.00	944,836.00
210304	Байрны түрээс		

2104	Хангамж, бараа материалын зардал	25,860,049.20	27,140,595.70
210401	Бичиг хэрэг	3,452,200.00	3,452,200.00
210402	Тээвэр, шатахуун	15,385,600.00	15,997,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,331,649.20	1,500,195.70
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,037,000.00	2,537,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,653,600.00	3,653,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,587,618.00	40,710,375.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,149,400.00	740,200.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	12,573,830.00	23,574,000.00
210604	Урсгал засвар	15,864,388.00	16,396,175.00
2107	Томилолт, зочны зардал	4,407,700.00	4,000,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4,407,700.00	4,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,529,876.00	30,280,676.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,794,500.00	23,929,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000.00	490,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,254,100.00	2,254,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,200.00	184,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	178,900.00	178,900.00
210807	Газрын төлбөр	565,476.00	565,476.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,060,700.00	2,580,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,055,656.95	32,781,296.68
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,438,256.95	32,781,296.68
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,438,256.95	32,781,296.68
213304	Хөрөнгийн		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	617,400.00	-
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага		
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	617,400.00	-
213404	Хөрөнгийн		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	84,950,812.00	53,534,625.00

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	84,950,812.00	53,534,625.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	84,950,812.00	53,534,625.00
2200	Дотоод эх үүсвэрээр	84,950,812.00	53,534,625.00
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	84,950,812.00	53,534,625.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(84,950,812.00)	(53,534,625.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,071,880,700.00	1,037,999,403.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,071,880,700.00	1,037,999,403.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,071,880,700.00	1,037,999,403.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	710,938,900.00	709,382,725.44
210101	Үндсэн цалин	396,054,000.00	394,497,825.44
210102	Нэмэгдэл	215,964,900.00	215,964,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,920,000.00	39,920,000.00
210104	Урамшуулал	59,000,000.00	59,000,000.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,747,100.00	92,842,374.35
210201	Тэтгэврийн даатгал	96,747,100.00	92,842,374.35
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,515,200.00	80,108,031.83
210301	Гэрэл, цахилгаан	56,400,000.00	31,413,483.61
210302	Түлш, халаалт	47,865,200.00	47,749,712.22
210303	Цэвэр, бохир ус	2,250,000.00	944,836.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	28,022,300.00	27,140,595.70
210401	Бичиг хэрэг	3,452,200.00	3,452,200.00

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	16,000,000.00	15,997,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,379,500.00	1,500,195.70
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,537,000.00	2,537,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,653,600.00	3,653,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	-	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,074,000.00	92,074,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,500,000.00	3,500,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,574,000.00	23,574,000.00
210604	Урсгал засвар	65,000,000.00	65,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,000,000.00	4,000,000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	4,000,000.00	4,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,583,200.00	30,471,676.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,224,000.00	24,120,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	492,000.00	490,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,254,100.00	2,254,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,200.00	184,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	99,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	178,900.00	178,900.00
210807	Газрын төлбөр	570,000.00	565,476.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,580,000.00	2,580,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,980,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,980,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,070,780,700.00	1,037,999,403.22
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,070,780,700.00	1,037,999,403.22
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,070,780,700.00	1,037,999,403.22
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	44.00	44.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	24.00	24.00
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.00	44.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		

650002	Төрийн тусгай албан хаагч (ГТ)	23.00	23.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Байхгүй.

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Аудитын Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Гаалийн газар нь Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд дэвшилтэт технологи, ухаалаг хяналт гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гаалийн ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 6 гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1129.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1046.9 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	-	-	-
Урьдчилгаа			
Бараа материал	37861.1	53390.7	15529.6
Үндсэн хөрөнгө	2899840.9	3931219.7	1031378.8
Нийт хөрөнгө	2937702.0	3984610.4	1046908.4
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2937702.0	3984610.4	1046908.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2937702.0	3984610.4	1046908.4

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст үлдэгдэлгүй байна. Тайлант оны эцэст үндсэн үйл ажиллагааны зардлаас 31.7 сая төгрөгийн, харуул хамгаалтын зардлаас 1.1 сая төгрөгийн, нийт 32.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд үйл ажиллагаатай холбоотой авлага үүсгээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15.5 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан болон хөрөнгө оруулалтаар ирсэн бараа материалын зарцуулаагүй үлдэгдэл нөлөөлжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй он удаан жил болсон бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл аж ахуйн материалын үлдэгдэл 9.8 сая төгрөгөөр, түлш, шатах тослох материалын үлдэгдэл 4.4 сая төгрөгөөр, бусад хангамжийн материалын үлдэгдэл 1.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. ГЕГ-аас 26.8 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй олгосон, 0.4 сая төгрөгийн шатахууны урамшуулалыг бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1031.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: тайлант онд төсвийн хөрөнгөөр 53.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, ГЕГ-аас 1414.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг 138.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн хамт хүлээн авсан. Тайлант онд 23.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг акталж, 71.0 сая төгрөгийн тээврийн хэрэгслийг шилжүүлсэн байна. Эдгээр тээврийн хэрэгслийн 94.0 сая төгрөгийн элэгдлийг данснаас хассан байна.

Тайлант онд ашиглаж буй үндсэн хөрөнгөд нийт 298.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна. Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлан онд үйл ажиллагаатай холбоотой өр үүсгээгүй байна. Тус газарт урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1046.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 1046.9 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 768.4 сая төгрөгөөр буюу 47.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 534.5 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 743.3 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

2021 онд их засварын санхүүжилтийг төсөвт суулгаж өгсөнтэй холбоотой нийт санхүүжилтийн дүн нэмэгдсэн байна. Цагааннуур дахь Улаан байшинтын уурын зуух, бохирын шугамын засвар, нэг айлын орон сууцны засварын төсвийг төсөвт суулгасан нь төсвийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 200.5 сая төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар үр дүн 1046.9 сая төгрөг байна. Өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Гаалийн ерөнхий газраас тус газрын анхны төсвийг 1046.2 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 1071.9 сая төгрөг болгон өөрчлөн баталсан ба анх баталсан төсвөөс 25.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1071.9 сая төгрөгийн төсөв баталснаас 1070.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 1.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1070.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1038.0 сая төгрөгийг зарцуулжээ. Үндсэн үйл ажиллагааны орлогоос төлөвлөсөн 1.1 сая төгрөг тасарсан байна.

Үндсэн санхүүжилтээс 32.8 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд: үндсэн үйл ажиллагааны төсвөөс 31.7 сая төгрөгийг, харуул хамгаалалтын зардлаас 0.1 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1038.0 сая төгрөг буюу 96.8 хувьтай байгаа нь тайлант оны батлагдсан төсвөөс цалингийн нэмэгдэл, урамшуулалт цалинг 1.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 3.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 26.4 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 1.1 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд тус газар нь Цагааннуур дахь Улаан байшинтын уурын зуух худалдан авах ажлыг 20.0 сая төгрөгөөр, бохирын шугамын засварын ажлыг 16.5 сая төгрөгөөр, 1 айлын орон сууцны засварын ажлыг 10.6 сая төгрөгөөр 2 компанитай шууд гэрээгээр гүйцэтгүүлж, хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна. Мөн төсвийн хөрөнгөөр 4.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэснийг орлогод авсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвөөс нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна. Байгууллага үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Гаалийн газар нь 2021 онд 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 117 мэдээллийг ил тод байршуулсан ба 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Шилэн дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 3 гүйлгээний 47.1 сая төгрөгийг байршуулсан эсэхийг түүвэрлэн шалгаж үзэхэд зөрчил дутагдал илрээгүй.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 заалт бүхий зөвлөмж өгөгдсний биелэлтийг хуулийн хугацаанд ирүүлсэн бөгөөд тайлант онд зөрчлийг давтан гаргаагүй, арилган ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх эсвэл анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн